

ӨМНӨХ ҮГ

ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэнгээс эрхлэн гаргадаг Эрдэм шинжилгээний бүтээл сэтгүүлийн 5 дахь дугаар хэвлэгдэн гарч байна. Энэхүү сэтгүүлд Монгол орны эрдэс, түүхий эдийн судалгаа, тэдгээрийг боловсруулах технологи, аргачлал болон байгалийн нэгдлийн хими, органик хими, эм судлал, уламжлалт анагаах ухаан, хүрээлэн буй орчны экологи, материал судлал зэрэг химийн олон салбарын судалгааны ололт амжилт, тэдгээрийн хэрэглээний чиглэлийн бүтээлүүдийг жил бүр хэвлэн нийтэлдэг билээ.

Эрдэм шинжилгээний бүтээл сэтгүүлийн №5-д нийт 15 эрдэм шинжилгээний өгүүлэл ирүүлснээс 11 өгүүлэл шаардлага ханган хэвлэгдэн гарч байна. Үүнд: органик химийн чиглэлээр -3, органик бус хими, материал судлалын чиглэлээр -4, экологийн химийн чиглэлээр 3, анагаах ухааны чиглэлээр 1 өгүүлэл хэвлэгдэж байна.

Эдгээр өгүүлүүдээс судлаач А.Анхтуяа нарын “Адуунчулууны ордын нүүрсний пиролизын давирхайн судалгаа” өгүүлэлд нүүрсийг халуун задралд оруулж, түүнээс гарсан хий, хатуу, шингэн бүтээгдэхүүний гарц бүрэлдэхүүнийг тогтоон, цаашлаад шингэн бүтээгдэхүүнийг нэрж колонкон хроматограф ба хийн хроматограф/масс спектрометр GC/MS-ийн багажит анализын аргуудаар нүүрсустөрөгчдийн найрлагыг тодорхойлсон нь нүүрсний цаашдын боловсруулалт болон хэрэглээнд онолын суурь мэдлэг болж өгч байна. Судлаач Б.Баяраа нарын “Завхан аймгийн зарим нуурын шаврын судалгааны дүнгээс” өгүүлэлд Завхан аймгийн Цагаан нуурын тойром, Цагаан нуурын шавар, шаврын уусмалын ерөнхий үзүүлэлтүүд, органик бодисын агуулга, эрдэс, элементийн найрлагыг судалсан нь тухайн ордуудын шаврын ангиллыг тогтоож, найрлага, физик үзүүлэлтээс нь хамааруулан шаврын эмчилгээний чиг хандлагыг тодорхойлж өгснөөрөө ач холбогдолтой юм. Доктор Л.Мөнхгэрэлийн “Тарималжуулсан эвэрлэг дэрвээлж (*pleurotus ostreatus*) мөөгний химийн найрлага болон эрдэс бодисын судалгаа” нь манай оронд тариалж худалдаанд нийлүүлж буй мөөгний найрлага, эрдэс бодисын агууламжийг харьцуулан тодорхойлсоноор уг мөөг нь тэжээллэг чанар сайтай, хүнс болон зохицуулах үйлчилгээтэй хүнсний нэмэлт болгон хэрэглэхэд тохиромжтой болохыг илтгэсэн судалгаа болсон юм. Харин эрдэс түүхий эдийн чиглэлээр хийгдсэн судалгааны ажил болох Доктор, профессор Г.Бурмаагийн “Хотгор ордын газрын ховор элементийн хүдэр ба эрдсийн шинж чанар” өгүүлэлд Газрын ховор элемент (ГХЭ) ийн хүдэр, ГХЭ агуулагч эрдсүүд, дагалдагч хоосон чулуулгын химийн найрлага, төрөл болон ширхэглэл, хатуулаг зэрэг физик, химийн үзүүлэлтийг судалсанаар ГХЭ-ийн хүдрээс ГХЭ-ийг баяжуулан ялгаж авах, баяжмалыг боловсруулах техник технологийн мэдлэгт ихээхэн ач холбогдол бүхий ажил болж байна. Хүрээлэн буй орчны экологийн чиглэлээр хэвлэгдэж буй судлаач Г.Одонтуяа, доктор О.Хүрэлдаваа нарын Монгол орны нүүрсхүчлийн хийтэй хүйтэн рашаануудын гидрохимийн судалгаа болон рашаан төст булгуудын химийн найрлагын харьцуулсан судалгаанууд нь Монгол орны зүүн бүсийн болон Төвийн бүсийн зарим нүүрсхүчлийн хийтэй хүйтэн рашаануудын физик, химийн найрлагыг тодорхойлсоноор тэдгээрийн эмчилгээний идэвх, ангиллыг тогтоосон байна. Мөн А.Цийрэгзэнгийн Хануй, Уньтын хүйтэн рашаануудын горимын судалгааг явуулсаны үндсэн дээр тэдгээр рашаануудад агуулагдаж буй элементүүд нь чихрийн шижин өвчинд нөлөөлөх эмчилгээний идэвхийг судалсан байна. Материал судлалын чиглэлээр хэвлэгдэж буй судлаач Б.Буянхишиг нарын судалгаанд орчин үеийн, байгаль орчинд ээлтэй технологи болох суперкритик усны аргаар мөнгөний нанопартикл гарган авч, мөн энэ аргаар идэвхжүүлсэн нүүрсний гадаргууд мөнгөний нанопартиклууд суулгах тохиромжтой горимыг тогтоосон нь манай орны нанотехнологийн шинжлэх ухааны хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж байгаа төдийгүй, гарган авсан шинэ материалууд нь анагаах ухааны салбарт болон ус цэвэршүүлэх ач холбогдол бүхий шингээгч материал болох боломжтой юм. Мөн материал судлалын чиглэлээр судлаач Ц.Эрдэнэбатын “Монгол орны түгээмэл тархацтай цахиурлаг эрдсээс шингэн шил гарган авах физик-химийн судалгаа” – нд манай оронд түгээмэл орших цахиурын өндөр агуулга бүхий хадан цагаан /өөхөн цагаан зэрэг түүхий эдүүдийг сонгон

авч химийн цахиурын хоёрч оксидтой харьцуулан шүлтийн металлын оролцоотой пирохимийн аргаар боловсруулан уусдаг метасиликат буюу шингэн шилний коллоид цахиурын золь тус тус бэлтгэх боломжтойг тогтоосон байгаа нь цахиур агуулсан эрдсүүдээс шингэн шил үйлдвэрлэх, эдийн засагт чухал ач холбогдолтой ажил болсон байна. Судлаач Н.Сугир-Эрдэнэ нарын судалгаагаар Монгол улсад төмрийн хүдрийн хамгийн том орд болох Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт орших Төмөртэйн ордын магнетитын хүдрийг хуурай, нойтон соронзон болон флотацийн аргаар баяжуулж, металлургийн үйлдвэрийн түүхий эдийн стандартын шаардлага хангасан хүхрийн агуулга багатай төмрийн баяжмал гарган авсан нь төмрийн хүдрийн хорт хольц болох хүхрийг бууруулснаар цаашид металлургийн үйлдвэрийн шаардлага хангасан өндөр цэвэршилтэй төмрийн баяжмалыг ялган авах боломжийг тодорхойлсон чухал ач холбогдолтой ажил болсон байна. Анагаах ухааны чиглэлээр хэвлэгдэж буй судлаач У.Хулан нарын судалгаагаар хүний үсэн дэх микроэлементийн агуулгын өөрчлөлтөөр хуйхны шинж чанар болох тослог, орчин, чийг, ба үсний ширхэгийн тоо, үсний диаметр зэргийн хоорондын хамаарлыг тогтоосноор Монголд үйлдвэрлэгдэж буй байгалийн гаралтай үс арчилгааны “ХАЛГАЙ” брэндийн бүтээгдэхүүний нөлөөг судалж тодорхойлсон шинэлэг ажил болсон байна.

Тус Эрдэм шинжилгээний бүтээл сэтгүүлд бүтээлээ ирүүлсэн нийт судлаачид болон сэтгүүлд ирүүлсэн бүтээлүүдэд шүүмж хийж бүтээлийн чанарыг сайжруулахад үнэтэй хувь нэмэр оруулж буй шүүмжлэгч нартаа талархал илэрхийлье! Та бидний хамтын ажиллагаа Монгол улсад химийн болон салбар дамнасан шинжлэх ухааныг хөгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

Улс орны хөгжлийн түлхүүр болсон Монгол улсын шинжлэх ухаан хөгжин цэцэглэх болтугай.

ЕРӨНХИЙ РЕДАКТОР Л.ЖАРГАЛСАЙХАН
С.ЭНХТУУЛ